

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭ,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САНХҮҮЖИЛТИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН
(2024 оны эхний хагас жил)**

2024 оны 07 дугаар сарын 01

Улаанбаатар хот

№	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Тэргүү хэсэг	Биелэлт	Гүйцэтгэл хувь	Санхүүжилт	Гүйцэтгэл	Үлдэгдэл төвлөрүүлсэн
					(мянган.төг)		
1	2	3	4	5	6	7	8
1.	Нийслэлийн Засаг даргын захирамж 2024.01.17 А/60	Гадаад сурталчилгааны ажил зохион байгуулах тухай	Улаанбаатар хотыг гадаад улсад сурталчлах, жуулчдыг хэрэгцээт мэдээ мэдээллээр хангах 4 төрлийн буюу Улаанбаатар сэтгүүлийг 6 орны хэлээр (Англи, Япон, Солонгос, Герман, Орос, Хятад) 10,000 ширхэг, Улаанбаатар хөтөч ном 2,000 ширхэг, жуулчдад зориулсан Улаанбаатар хотын газрын зураг "City map" 5,000 ширхэг, жим сэтгүүл 1,000 нийт 18,000 ширхэг сурталчилгааны материал хэвлүүлж Монгол Улсад суугаа Элчин сайдын яамд, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоод, жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүд болон гадаад, дотоодод зохион байгуулагдсан олон улсын үзэсгэлэн, уулзалт, хурал, эвент арга хэмжээнүүдэд тарааж Улаанбаатар хотыг сурталчлан ажиллаж байна.	100	90,900,000.00	90,609,000.00	291,000.00
2.	Нийслэлийн Засаг даргын захирамж 2024.01.17 А/61	Улаанбаатар хотын жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийн талаар авах зарим арга хэмжээний тухай	Гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүдийг 7 байршилд буюу Нийслэлийн Засаг захиргааны IV байр, "Төв шуудан", ХБНГУ-ын Фрайбург хот, "Чингис хаан" олон улсын нисэх онгоцны буудалд байрлах жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүдийг тогтмол, "Тэрэлж Монгол олле", "Хонхор тосгон Монгол олле", "Сөүлийн гудамж Монгол олле" төвүүдийг улирлын чанартай ажиллуулж, жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүдээр 2024 оны эхний хагас жилийн 5,187 гаруй гадаад, дотоодын иргэн, жуулчдад үйлчилгээ үзүүлж, жуулчдын санал, хүсэлтийг хүлээн авах	100	96,687,500.00	96,687,500.00	-

			лавлах 118 тусгай дугаарын утсаар 1,369 хүнд шаардлагатай мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа.				
3.	Нийслэлийн Засаг даргын захирамж 2024.01.19 А/82	“Улаанбаатарын өвлийн наадам” арга хэмжээг зохион байгуулах тухай	Улаанбаатар хотод өвлийн болон тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, өвлийн үндэсний болон орчин үеийн экстрим спортыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор “Улаанбаатарын өвлийн наадам-2024” арга хэмжээг 2024 оны 01 дүгээр сарын 26-28-ны өдрүүдэд “Скай резорт” цанын бааз, “Уухайн дуу” жуулчны бааз, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд тус тус зохион байгуулж наадмын үеэр Монгол туургатны мөсөн сурын аварга шалгаруулах тэмцээн, Мөсний шагайн улсын аварга шалгаруулах тэмцээн, Параглайдингийн (уулын шүхэр) хотын аварга шалгаруулах тэмцээн, Цасны Регбигийн хотын аварга шалгаруулах тэмцээн, Снөүбоардын тэмцээн зэрэг 5 төрлийн уралдаан тэмцээн зохион байгуулж ОХУ-ын Бүгд найрамдах Буриад улс, Бүгд найрамдах Тува улс, БНХАУ-ын ӨМӨЗО, Шинжаан Уйгур зэрэг Монгол туургатан улсаас 34, Монгол Улсын 21 аймгаас 750, Улаанбаатар хотоос 332 нийт 1,114 тамирчин оролцов. Арга хэмжээний үеэр иргэд, сонирхогчдын дунд мөсөн сур, мөсний шагай, гэр бүлийн буухиа, олс таталтын тэмцээн зохион байгуулж, урлагийн тоглолт, орен тис, параглайдингийн үзүүлбэр, шувуулахуйн үзүүлбэр, тайга нохдын үзүүлбэр, цана чарганы үйлчилгээ, хоол ундны үйлчилгээ, цаа буга, тэмээ унах үйлчилгээг зохион байгуулж арга хэмжээг нийт 12,000 гаруй гадаад, дотоодын иргэд, жуулчид үзэж сонирхлоо	100	110,959,800.00	92,535,300.00	18,424,500.00
4.	Нийслэлийн Засаг даргын захирамж 2024.01.23 А/90	“Мазаалай олон улсын цас мөсний наадам” арга хэмжээг зохион байгуулах тухай	Аялал жуулчлалын салбарын улирлын хамаарлыг бууруулах, өвлийн улирлыг уртасгах, жуулчдын урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Соёлын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой хамтран “Мазаалай” олон улсын цас мөсний наадмыг 2024 оны 01 дүгээр сарын 14-28-ны өдрүүдэд “Скай резорт” цанын баазад анх удаагаа зохион байгууллаа.	100	94,780,740.00	89,295,240.00	5,485,500.00

			<p>Монголын үндэсний бахархалт амьтан Мазаалайг хайрлан хамгаалах зорилгоор “Мазаалай мөсөн хотхон”-д 53 мазаалай, 50 метрийн урттай мөсөн гулсуур, 4000 м.кв мөсөн гулгалтын талбай, 12 метрийн өргөнтэй 18 метрийн урттай нэг цагт хамгийн олон хүн гулгах мөсөн гулсуур, Мазаалай бамбаруушнуудыг дүрсэлсэн 5 метр өндөртэй цас мөсөн баримлуудыг бүтээж өдөр бүр урлаг, соёл, спортын арга хэмжээг зохион байгуулж нийт 90,000 гаруй хүн “Мазаалай мөсөн хотхон”-оор үйлчлүүлэв. “Мазаалай” олон улсын цас мөсний наадмын үеэр 12 метр өргөнтэй, 18 метр урттай мөсөн гулгуураар 1 цагийн дотор 408 хүн гулгаснаар Гиннесийн дээд амжилтыг тогтоож, Монгол орны өвлийн аялал жуулчлал дэлхийн газрын зурагт тэмдэглэгдсэн. “Мазаалай” олон улсын цас мөсний наадмын хүрээнд “Save MAZAALAI” сэдэвт олон улсын мөсөн сийлбэрийн тэмцээн 2024 оны 01 дүгээр сарын 14-17-ний өдрүүдэд зохион байгуулагдаж тэмцээнд АНУ, ОХУ, БНХАУ, Тайвайн, Франц, Монгол 6 улсын 12 баг, уран бүтээлчид оролцож тэргүүн байрт Франц Улсын баг, дэд байрт Монгол Улсын баг, гуравдугаар байрт Бүгд найрамдах Саха Улс (Якут)-ын баг уран сийлбэрчид шалгарлаа.</p>				
5.	Нийслэлийн Засаг даргын захирамж 2024.02.01 А/104	Дэмжлэг үзүүлэх тухай	<p>“Монголд зочлох жил”-ийн хүрээнд аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын чанар, хүртээмжийг сайжруулах, тогооч нарын ур чадварыг дээшлүүлэх, жуулчдад зориулсан хоолны нэр төрлийг нэмэгдүүлэх, жуулчинд үйлчлэх мэргэжлийн чадвартай тогооч нарыг бэлтгэх, олон улсаас туршлага солилцох зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, “Монголын ресторан зоогийн газруудын холбоо” ТББ хамтран “Олон үндэстний хоолны тогооч бэлтгэх” Гастро аялал 2024 сургалтын хөтөлбөрийг гадаад, дотоодын сургалт гэсэн хоёр шаттай зохион байгууллаа. Хөтөлбөрийн хүрээнд 1 дүгээр үе шат буюу гадаад сургалтыг аялал жуулчлал, зочлох үйлчилгээ, үндэсний хоол зоогоороо дэлхийд алдартай</p>	100	243,600,000.00	243,600,000.00	-

			аялал жуулчлал өндөр хөгжсөн БНСУ, БН Узбекистан улс, ОХУ, Турк, Хонг Конг, Тайланд зэрэг 6 улсад 2024 оны 03 дугаар сарын 09-ний өдрөөс 05 дугаар сарын 10-ны өдрүүдэд 7-10 хоногийн онол, дадлага хосолсон мэргэжлийн тогоочийн сургалтад 56 тогоочийг хамруулав.				
6.	Нийслэлийн Засаг даргын захирамж 2024.01.21 А/175	Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зарим арга хэмжээний тухай	Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, хот орчмын байгалийн үзэсгэлэн, соёл, ахуй байдлыг сурталчлан таниулах, иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Монголын явган алхалтын холбоо” ТББ-тай хамтран “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль-2024” арга хэмжээг 2024 оны 03 дугаар сарын 02,03-ны өдрүүдэд зохион байгуулав. Фестивальд “Монголын явган алхалтын холбоо”-ны салбар холбоод буюу нийслэлийн 9 дүүрэг, Дархан-Уул, Орхон, Төв, Хэнтий, Дорноговь, Өмнөговь, Сэлэнгэ, Баян-Өлгий, Увс зэрэг 10 аймгийн явган алхалтын клубүүдийн 600 гаруй алхагчид оролцож, 2024 оны 03 дугаар сарын 02-ны өдөр Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгээс Скай резорт цанын бааз буюу “Туул өртөө” хүртэл 10км, 2024 оны 03 дугаар сарын 03-ны өдөр Олон улсын хүүхдийн “Найрамдал” зуслангаас “Жавхлант өртөө” хүртэл 10км маршрутаар алхалт хийж, оролцогчдын дунд мөсөн шагайн тэмцээн, олс таталтын тэмцээн зохион байгууллаа.	100	14,550,000.00	14,550,000.00	-
7.	Нийслэлийн Засаг даргын захирамж 2024.02.22 А/180	“Бүргэдийн баяр” арга хэмжээг зохион байгуулах тухай	Казах үндэстний ёс зан заншил, өв уламжлал, дахин давтагдашгүй өвөрмөц соёлыг сурталчлан таниулах, залуу үедээ өвлүүлэн үлдээх, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, “Монголын бүргэдчид холбоо” ТББ, “Чингис хааны хүрээ” аялал жуулчлалын цогцолбор хамтран “Бүргэдийн баяр-2024” арга хэмжээг 2024 оны 03 дугаар сарын 09,10-ны өдрүүдэд “Чингис хааны хүрээ” аялал жуулчлалын цогцолборт 18 дахь жилдээ зохион байгууллаа. “Бүргэдийн баяр-2024” арга хэмжээнд Баян-Өлгий, Төв аймгуудаас хүрэлцэн ирсэн 21 шилдэг бүргэдчин оролцож бүргэдтэй парад,	100	20,050,000.00	19,980,000.00	70,000.00

			<p>бүргэдчидийг танилцуулж алдаршуулах арга хэмжээ болон бүргэдчидийн дунд бүргэдээр шьрга (хиймэл ан) бариулах тэмцээн, бүргэдээ хэрхэн сайн сургасан байдлыг шалгаруулах тэмцээн, Казак үндэсний тоглоом көкбар (тулам булаалдах) тэмцээн, зоос шүүрэх тэмцээнүүдийг зохион байгуулав. Арга хэмжээний үеэр Үндэсний урлагийн их театр, Баян-Өлгий аймгийн Соёлын төвийн уран бүтээлчдийн тоглолт, “Морьтон баатруудын шоу тоглолт”, “Тайга анч нохдын үзүүлбэр”, “Уулын шүхрийн үзүүлбэр” болон тойром бүжиг, цаа буга, тэмээ, морь унах, бүргэд шувуу болон тэмээтэй зураг даруулах болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчийн үзэсгэлэн худалдааг зохион байгуулж “Бүргэдийн баяр-2024” арга хэмжээг 2 өдрийн турш давхардсан тоогоор 20,000 гаруй хүн үзэж сонирхлоо.</p>				
8.	Нийслэлийн Засаг даргын захирамж 2024.03.28 А/341	Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, үзэсгэлэн, арга хэмжээнд оролцох тухай	<p>1.“Монголд зочлох жил”-ийн хүрээнд Монгол Улс, Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Байгаль орчин аялал жуулчлалын яам, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, “Хүннү Айр” хамтран “GO MONGOLIA” ROAD SHOW-2024 арга хэмжээг БНХАУ-ын Гуанжоу, Хонгконг, Бээжин хотуудад 2024 оны 04 дүгээр сарын 25-29-ний өдрүүдэд амжилттай зохион байгууллаа. “GO MONGOLIA” ROAD SHOW арга хэмжээний үеэр 2024 онд Монгол Улс, Улаанбаатар хотод зохион байгуулагдах олон улс болон үндэсний хэмжээний чанартай эвент арга хэмжээний нэгдсэн танилцуулгыг оролцогчдод хүргэж, Улаанбаатар хотын сурталчилгааны 400 ширхэг (Англи, Хятад хэлд дээр хэвлэсэн) сэтгүүлийг оролцогчдод тарааж мөн Улаанбаатар театрын уран бүтээлчид үндэсний урлагийн тоглолтоо зохион байгуулав.Арга хэмжээнүүдийн үеэр зохион байгуулагдсан В2В уулзалтад Монгол Улсын 21, БНХАУ-ын 175 аялал жуулчлалын тур оператор компаниуд оролцож хамтран ажиллах гэрээ байгуулж давхардсан тоогоор 800 гаруй хүн оролцоо.</p>	100	124,838,070.40	124,655,570.40	182,500.00

			<p>2.Монгол Улс, Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Байгаль орчин аялал жуулчлалын яам, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой хамтран БНСУ-ын Сөүл хотноо 2024 оны 05 дугаар сарын 09-12-ны өдрүүдэд зохион байгуулагдсан 39 дахь удаагийн "SEOUL INTERNATIONAL TRAVEL FAIR-2024" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд оролцлоо. Үзэсгэлэнд 40 гаруй улс орны 400 гаруй байгууллага оролцсон бөгөөд Монгол Улсаас Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо болон 10 тур оператор компаниуд хамтран "GO MONGOLIA" уриа доор Монгол Улс, Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлан, арга хэмжээний үеэр 2024 онд Монгол Улс, Улаанбаатар хотод зохион байгуулагдах олон улс болон үндэсний хэмжээний чанартай эвент арга хэмжээний нэгдсэн танилцуулгыг хүргэж, Улаанбаатар театрын уран бүтээлчид үндэсний урлагийн тоглолтоо зохион байгуулав. "SITF" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Монгол улс "GO MONGOLIA" аялал жуулчлалын брэндигээ сурталчлан танилцуулж "Шилдэг PR маркетингтай Booth"-ээр шалгарлаа.</p>				
9.	Нийслэлийн Засаг даргын захирамж 2024.05.08 А/525	Сургалт зохион байгуулах тухай	<p>Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын хүний нөөцийн мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, үйлчилгээний чанар, харилцааг сайжруулах зорилгоор "Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо", "Эксперт хоспиталити" ХХК-тай хамтран Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа жуулчны үйлчилгээний байгууллагын удирдах болон үйлчилгээний ажилчдад зориулсан онол, дадлага хосолсон "Олон улсын эксперт багштай зочлох үйлчилгээний сургалт"-ыг 2024 оны 05 дугаар сарын 06-09-ний өдрүүдэд зохион зохион байгууллаа. Сургалтыг БНСУ-ын "СЭЖУН" их сургуулийн зочлох үйлчилгээний доктор багш, "STAZ HOTEL" зочид буудлын ерөнхий менежер Профессор</p>	100	20,560,000.00	20,560,000.00	-

			Кyu Sun Kang /Ph.D/ болон тус сургуулийн Зоогийн газрын үйлчилгээний доктор багш Lee Mi-young /Ph.D/ нар удирдан явуулж сургалтад зочлох үйлчилгээний салбарын 163 хүн хамрагдлаа.				
10.	Нийслэлийн Засаг даргын захирамж 2024.05.08 А/526	“Тэнгэр” олон улсын фестиваль зохион байгуулах	Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, нүүдэлчин угсаатны уламжлалт ёс заншлын салшгүй чухал соёлын өв болох бөөгийн ёс заншил, зан үйлийг олон нийтэд таниулах, соёл, шашны аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор “Тэнгэр” олон улсын бөөгийн фестиваль арга хэмжээг “Тэнгэр тайлал” төрийн бус байгууллагатай хамтран 2024 оны 05 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд “Хүй долоо худагт” 2 дахь жилдээ зохион байгууллаа.Нэгдсэн арга хэмжээний хүрээнд 2024 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Чингис хааны Үндэсний музейн хурлын танхимд зохион байгуулагдсан “Дэлхийн бөөгийн эрдэм шинжилгээний хурал”-д Нийслэлийн Бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Хадбаатар, НҮБ-ын суурин зохицуулагч Талан Мишра нар болон 300 гаруй бөө мөргөлчид, эрдэмтэн судлаачид оролцож бөөгийн үүсэл хөгжил, бөө тэнгэр шүтлэгийн хүн төрөлхтөнд үзүүлэх ач холбогдол, бөө өөрийн нутаг орон, байгалийнхаа төлөө хийх зан үйл зэрэг сэдвүүдийн хүрээнд илтгэл хэлэлцүүлэг зохион байгуулагдав.“Тэнгэр” олон улсын бөөгийн фестивальд арга хэмжээнд Франц, Польш, АНУ, Канадын уугуул индиан, Бүгд Найрамдах Солонгос Улс, БНХАУ-ын ӨМӨЗО, ОХУ-ын Буриад зэрэг 30 улсын 250 гаруй бөө, Монгол Улсаас 19 холбооны 500 гаруй нийт 750 гаруй бөө оролцож нар тахих ёслол, бөөгийн туг сүлд залах ёслол, тэнгэрийн дуудлага зан үйл, гал тахих ёслол болон бөө мөргөлийн зан үйл үзүүллээ. Арга хэмжээний үеэр хүчит бөхийн барилдаан, хурдан морины уралдаан (соёолон нас), сурын харваа, шагайн харваа (өсвөрийн насны тамирчид) болон урлагийн тоглолт, шувуулахуйн үзүүлбэр, морьтон баатруудын үзүүлбэр болон жижиг, дунд үйлдвэрлэл	100	132,879,560.00	132,867,960.00	11,600.00

			эрхлэгчийн үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, арга хэмжээг давхардсан тоогоор 10,000 гаруй хүн үзэж сонирхлоо.				
11.	Нийслэлийн Засаг даргын захирамж 2024.05.21 А/585	“Улаанбаатар травэл экспо-2024” аялал жуулчлалын үзэсгэлэн зохион байгуулах тухай	“Улаанбаатар травэл экспо-2024” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг Улаанбаатар Аялал жуулчлалын холбоотой хамтран 2024 оны 05 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд 10 дахь жилдээ Мишээл экспо төвийн үзэсгэлэнгийн танхимд зохион байгууллаа. Үзэсгэлэнд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Аялал жуулчлалын танхим, БНСУ-ын “Korea Tourism Organization”-ын 17, Монгол Улсаас Өмнөговь, Дархан, Ховд, Завхан, Увс зэрэг 5 аймаг болон нийт 87 байгууллага, аялал жуулчлалын тур оператор компани, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид аяллын дагалдах хэрэгсэл, бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагаагаа танилцуулан оролцож арга хэмжээг давхардсан тоогоор 6,000 гаруй хүн үзэж сонирхлоо.	100	27,500,000.00	27,500,000.00	-
12.	Нийслэлийн Засаг даргын захирамж 2024.05.30 А/615	“Талын салхи-2024” олон улсын мото наадам зохион байгуулах тухай	Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор “Скаллс” мото клубтэй хамтран “Талын салхи-2024” олон улсын мото наадмыг 9 дэх жилдээ 2024 оны 06 дугаар сарын 08-09-ний өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбай болон Цонжинболдог дахь Чингис хааны хөшөөт цогцолборт зохион байгууллаа. Наадамд ОХУ-аас 200, БНХАУ-аас 70, БНСУ-аас 10, Монгол Улсаас Улаанбаатар хот болон 21 аймгийн 40 клубын 1500 гаруй нийт 1900 гаруй мотоцид оролцож арга хэмжээг 10,000 гаруй хүн үзэж сонирхлоо. Энэ жилийн наадам шинэлэг өнгө аясыг илэрхийлсэн мото спортын соёлыг таниулах, үзэсгэлэн худалдаа, энтэртайнмент агуулсан мото хөлөглөгчид, мото сонирхогчид, хөгжимд дурлагсад гэсэн 3 хэсэгт арга хэмжээг зохион байгууллаа.	100	96,043,410.00	96,043,410.00	-
13.	Нийслэлийн Засаг даргын захирамж 2024.06.03 А/647	Аялал жуулчлалын арга хэмжээ зохион байгуулах тухай	Франц Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, “Аллианс франсайз” төвтэй хамтран “Франц хэлтнүүдийн хотхон-2024” соёл, аялал жуулчлалын өдрүүд” арга хэмжээг 2024 оны 06 дугаар сарын 08-ны өдөр	100	17,000,000.00	17,000,000.00	

		<p>Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд зохион байгуулж арга хэмжээнд Франц хэл дээр үйл ажиллагаа явуулдаг 80 гаруй дипломат болон боловсрол, соёл, худалдаа, аялал жуулчлалын байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаагаа танилцуулж, олимпын наадам 100 жилийн дараа Парист эргэн ирснийг тохиолдуулан "Парис-2024" олимпын наадмын талаар сонирхолтой мэдээллүүдийг хүргэж, дэлхийд алдартай хөгжмийн баярын тоглолтууд, орен тис-үүд, францын алдарт петанк спортын тэмцээн зэрэг соёл, урлаг спортын арга хэмжээнүүд зохион байгуулагдаж нийт 3000 гаруй хүн арга хэмжээг үзэж сонирхсон.</p>				
Нийт 13 захирамж			100	1,090,349,080.00	1,065,883,980.00	24,465,100.00

ТАНИЛЦСАН:
ДАРГА



Д.БАТСҮХ

НЭГТГЭСЭН:
БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЙЛАН,
СУРГАЛТ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

(Signature) О.НЯМБАТ